



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/95

Хужирт сум

Газрын байршил өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 5.1.3.2, 5.1.3.5 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Батсуурийн Хашбат (ХП76112371)-ын эзэмшлийн 6211004366 нэгж талбарын дугаартай Худалдаа, нийтийн үйлчилгээний газар төв цогцолбор зориулалт бүхий 960м2 газрын зарим хэсэг нь Улсын төсвийн хөрөнгөөр сумын төв дотор шинээр тавигдах хатуу хучилттай авто замын трасстай давхардаж байгаа тул зүүн тийш 6 м зайд шилжүүлж байршлыг өөрчлөн үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомжид заасан хүрээнд эзэмших эрхээ хэрэгжүүлэх, иргэний газар эзэмших эрхийн гэрчилгээг шинэчлэн солиулахыг эзэмшигчид, эзэмшсэн газрын мэдээллийг газрын кадастрын системд засварлах, баталгаажуулах, эзэмшигчийг хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллахыг газрын даамал(Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2023оны 05 дугаар сарын 01-ний өдрийн "Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай" А/68 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ